



「ЗОХИЦУУЛАЛТТАЙ ЭТГЭЭДҮҮДЭД」

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
АЖЛЫН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84
E-mail: info@frc.mn, http://www.frc.mn

2021.11.10 № 3/3903
танай _____-ны № _____-т

「 Аж ахуйн нэгжийн улсын тооллогод
хамрагдах тухай

Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.5 дахь хэсэгт тус тус заасны дагуу Аж ахуй нэгжийн улсын тооллогыг 1991 оноос хойш 5 жил тутам зохион байгуулдаг бөгөөд үүний 7 дахь удаагийн тооллогыг Үндэсний статистикийн хорооноос 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл зохион байгуулж байна.

Энэ ажлын хүрээнд аж ахуйн нэгжүүд нь тооллогод идэвхтэй хамрагдсанаар эдийн засгийн бүтэц, хөгжлийн чиг хандлага илэрхийлэгдэх суурь мэдээлэл бүрдэх, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагыг эрхэлж байгаа ажил, үйлчилгээний чиглэл, байршлаар нь үнэн зөв тогтоож, улс орны эдийн засгийн хөгжилд оруулж буй хувь нэмрийг тодорхойлох, статистикийн судалгаа, түүвэр ажиглалтын хамрах хүрээг бүрэн тогтооход чухал ач холбогдолтой.

Үүний хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтад хамаарагдах үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд, хувь хүн, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагууд <https://toollogo.1212.mn> цахим хаягаар хандан бүртгүүлнэ үү.

Зохицуулалттай этгээдүүд аж ахуйн нэгжийн улсын тооллогод бүртгүүлэхдээ www.toollogo.1212.mn цахим хуудас руу орж, аж ахуйн нэгжүүд татварын цахим систем /www.etax.mta.mn/-д бүртгэлтэй хаягаараа хамрагдах, иргэний хувьд татвар төлөгчөөр бүртгэлтэй бол татварын цахим системээр эсвэл www.e-mongolia.mn системд бүртгэлтэй хаягаараа тус тус нэвтэрч орно.

Санхүүгийн зохицуулах хорооны зохицуулалтын хүрээнд хамаарагдах санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч этгээдүүд аж ахуйн нэгж байгууллагын улсын тооллогод дээрх хугацаанд идэвхтэй хамрагдан, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана уу.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ



15160000001